

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2022 оны 04 дугаар сарын 05-ний өдрийн
А/60 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАШУУНСУХАЙТ, ШИВЭЭХҮРЭН БООМТ ОРЧМЫН ХИЛИЙН ЗУРВАСТ ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ АГУУЛАХЫН БАЙГУУЛАМЖИЙГ ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР БАРЬЖ БАЙГУУЛАХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 14 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Өмнөговь аймаг дахь Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах (цаашид “Төсөл хэрэгжүүлэх” гэх) гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, хэлцэл хийнэ.

1. Зорилго

Газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэвийн бус өсөлт, хангамжийн тасалдал, хомсдол үүсэх нөхцөлд зохицуулалт хийх, импортолж байгаа газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг хилийн боомтуудад хийх бодлогыг хэрэгжүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төслийг мэргэжлийн өндөр төвшинд, техник технологийн оновчтой шийдлээр гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулахад оршино.

2. Хамрах хүрээ

Газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын байгууламжийг барьж байсан туршлагатай, санхүүгийн болон техникийн чадвар бүхий газрын тосны бүтээгдэхүүн импортлогч хуулийн этгээд болон уг хуулийн этгээд нь бусад этгээдтэй түншлэлийн үндсэн дээр төсөл боловсруулан оролцох боломжтой.

3. Сонгон шалгаруулалтын хугацаа, бүртгэл

Төсөл хэрэгжүүлэх сонирхолтой хуулийн этгээдийн зүгээс Төслийг хэрэгжүүлэх саналаа боловсруулан энэ удирдамжийн 4-т заасан баримт бичгийн хамт битүүмжлэн ирүүлэх ба материалыг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 12:00 цагаас өмнө УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын газарт Ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгсөн байна.

4. Төсөлд орцогчид тавигдах шаардлага, ирүүлэх баримт бичиг.

Өмнөговь аймаг дахь Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтад төсөл ирүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна.

- Газрын тосны бүтээгдэхүүний импортын үйл ажиллагаа явуулж байсан туршлагын нотлох баримт;
- Газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын байгууламжийг барих санхүүгийн чадварыг илэрхийлсэн баталгаа ирүүлэх;
- Аж ахуйн нэгж нь сүүлийн 2 жилд дараалан ашигтай ажилласан, татварын өргүй талаарх баримт буюу сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажсан тайлан ирүүлэх;
- Газрын тосны бүтээгдэхүүний импортын болон бөөний худалдааны тусгай зөвшөөрөлтэй байх;
- Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдтэй адил тэнцүү, харилцан тэгш хамтран ажиллах баталгаа гаргах;
- Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын байгууламжийг барьж байгуулах, эзэмших, ашиглах талаар үүрэг, хариуцлагыг тодруулсан гэрээний загварыг ирүүлсэн байх;
- Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ баталсан тодорхойлолт ирүүлэх;
- Төслийг хамтад нь эсхүл тус тусад нь хэрэгжүүлэх эсэх талаарх санал ирүүлэх;

5. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам.

Төсөлд оролцогч нь Шивээхүрэн, Гашуунсухайт боомт тус бүр дээр газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулахын төслийг хэрэгжүүлэх ТЭЗҮ-ийг ирүүлэх ба доорх 7 шалгуур үзүүлэлт тус бүрээр оноо өгч хамгийн их оноо авсан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна. Үүнд:

- 1) Байгууламжийн хүчин чадал,
- 2) Шилжүүлэн ачилтын зардал,
- 3) Шилжүүлэн ачих үйлчилгээний үнэ,
- 4) Төслийн нийт төсөвт өртөг,
- 5) Барьж байгуулахад шаардлагатай хугацаа,
- 6) Санхүүгийн чадавхыг илэрхийлсэн баталгаа,
- 7) Төрийн өмчит хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний үнэ, нөхцөлийн талаарх мэдээлэл.

Дээрх шалгуур үзүүлэлтүүдийн саналыг ирүүлээгүй бол 0 оноо, санал ирүүлсэн бол 3 оноо, хамгийн сайн ирүүлсэн санал 5 оноо өгч, ирүүлсэн санал бүрийг харьцуулан, ажлын хэсгийн гишүүд тус бүр үнэлгээ өгнө. Нэгдсэн үнэлгээг ажлын хэсгийн нарийн бичиг санал өгсөн гишүүдийн тоогоор дундчилан нийлбэр дүнг гарган хамгийн өндөр оноо авсан аж ахуйн нэгжийг Ажлын хэсэг сонгон шалгаруулна.

6. Төслийн шалгаруулалт

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар батлагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн сонгон шалгаруулалтад оролцогчдын ирүүлсэн төслийг ил тод, шударга өрсөлдөөний зарчимд тулгуурлан дээрх үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу ажлын 5 хоногт багтаан шалгаруулна.

- Шалгаруулалтыг ажлын хэсгийн гишүүдийн урьдчилан товлосон хугацаанд, 100% ирцтэйгээр ирүүлсэн материалын битүүмжийг нээснээр эхлүүлнэ.
- Шалгарсан төслийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад танилцуулж, сонгон шалгаруулалтыг баталгаажуулна.
- Шалгарсан болон шалгараагүй хуулийн этгээдэд холбогдох мэдэгдлийг ажлын 1 хоногт багтаан мэдэгдэнэ.
- Ажлын хэсэг нь шалгарсан хуулийн этгээдтэй гэрээний төслийг хэлэлцэн, эцэслэсэн төслийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад танилцуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Газрын тосны бодлогын газрын дарга гэрээнд гарын үсэг зурна.
- Хэлцэл хийх явцад 1-т орсон оролцогч хэлцэл хийхээс татгалзсан бол сонгон шалгаруулалтад санал өгсөн онооны дарааллаар 2-т орсон оролцогчтой хэлцэл хийх эрх үүсэх ба 2 дахь оролцогч зөвшөөрөөгүй бол дараагийн оролцогчтой хэлцэл хийх зарчмаар явна.
- Ажлын хэсгийн гишүүн нь оролцогч аж ахуйн нэгжтэй ашиг сонирхлын зөрчилгүй байх. Ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ талаар мэдэгдэж үнэлгээнд оролцохгүй байх.

---oOo---